



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А129

Хажуу шинэ-Ус

Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2024 оны 04 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 04 сарын 18-ны хүртлэх хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг Угтаал чандмань хоршоо мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Д.Амгалан)-д үүрэг болгосугай.

2. Малчин мал бүхий өрхөд зарлан мэдээлэл хүргэж ажиллахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Мөнхдэлгэр), 2 дугаар багийн Засаг дарга (М.Амарзаяа), 3 дугаар багийн Засаг дарга (Б.Даваасүрэн) нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтын ажилд хяналт тавин мэргэжлийн арга зүйгээр хангаж үр дүнг тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.АРИУНАА



482401029